



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны "2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай" 49 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарлаж холбогдох хууль тогтоомж, шаардлагыг зөрчиж томилогдсон этгээдийг олж тогтоон, ажлаас чөлөөлөхийг үүрэг болгосны дагуу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад "Шүүр" ажиллагааны хэрэгжилтийг хангаж, шаардлагыг зөрчиж томилогдсон этгээдийн талаарх мэдээллийг нэгтгэн танилцуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч:

Ц.Баяр-Эрдэнэ

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

В.Дарханбаатар

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Удирдлага, төлөөллийн албаны дарга

Ц.Шинэхүү

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны дарга

Д.Одмаа

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Г.Дэлгэрмаа

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

А.Молор

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Д.Дариймаа

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичиг:

ТӨБЗГ тушаал-/2023

130003114

Б.Амарбаясгалан


Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн  
мэргэжилтэн

Г.Нямдаваа

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн  
мэргэжилтэн

2. Холбогдох хууль тогтоомж, шаардлагыг зөрчиж томилогдсон этгээдүүдтэй холбоотой мэдээлэл, үр дүнг 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөрт багтаан танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 23  
.....-ний өдрийн 1/28 дугаар тушаалын хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

### Нэг: Зорилго

Монгол Улсын Засгийн газраас Авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж, авлига, хууль бус үйлдэлтэй үл эвлэрэх, үл тэвчих хандлагыг олон нийтийн дэмжлэг, оролцоотойгоор төлөвшүүлэн бүх шатанд авлигыг таслан зогсоосны үндсэн дээр хүний эрхийг ханган нийтийн эрх ашгийг хамгаалж, хувийн хэвшлийг дэмжин хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах зорилгоор 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарлаж, авлигатай тэмцэх "шүгэл, шүүр, шувуу, шилжүүлэн авах, шил" ажиллагааг хэрэгжүүлэхээр тогтсны дагуу төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад "Шүүр" ажиллагааны хэрэгжилтийг хангаж, шаардлагыг зөрчиж томилогдсон этгээдийн талаарх мэдээллийг нэгтгэн танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг энэхүү удирдамжийг баримтална.

### Хоёр: Санал, дүгнэлт гаргах чиглэл

Ажлын хэсэг дараах чиглэлээр санал, дүгнэлт гаргана:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх;
2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн дүрмээр тогтоосон журмын дагуу томилогдсон эсэх;
3. Ажил үүргийн тодорхойлолтод заасан мэргэжил, мэргэшил, ур чадварын болон бусад шаардлагыг хангасан эсэх;
4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг"-ийг Авлигатай тэмцэх газраар хянуулаагүй томилогдсон, хөрөнгө орлогоо мэдүүлэх үүргээ биелүүлсэн эсэх.

### Гурав: Үр дүн, хугацаа

Ажлын хэсгийн тайлан, цаашид авах арга хэмжээний талаарх санал дүгнэлтээ боловсруулан 2023 оны 04 дүгээр сарын 05-ны дотор багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулах.

-----oOo-----